БАТЛАВ.
Байгаль орчин, Уур амьсгалын
өөрчлөлтийн яамны Хүрээлэн буй орчны
бодлого үнэлгээний газрын дарга
_____ / Г.Энхмөнх /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:
"Макс Пауэр" ХХК-ийн Гүйцэтгэх
захирал
_____ /Х.Төмөрбаатар /

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ 300 МВт ХҮЧИН ЧАДАЛТАЙ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/ АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5648092 /

Хянасан:
БОУАӨЯ-ны Байгаль орчны үнэлгээ,
аудитын хэлтсийн мэргэжилтэн
_____ / З.Азжаргал /

Боловсруулсан:
"Макс Пауэр" ХХК-ийн
Орон нутаг зөвшөөрөл хариуцсан
мэргэжилтэн:
_____ / Б.Цэрэнмягмар /

2026 он

ГАРЧИГ

1. Төслийн товч танилцуулга 3
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт 4
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт 5
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт 6
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 8
6. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 11
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 12
8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 12
9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө 14
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 16
11. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө..... 19
12. Төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө..... 21

1. Төслийн товч танилцуулга

1.1 Оршил

Монгол Улсын Баруун бүсийн эрчим хүчний бие даасан, найдвартай байдлыг хангах, үйлдвэржилт болон бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт орших Хүрэн голын 185.9 сая тонн нөөцтэй нүүрсний ордыг түшиглэн 300 МВт хүчин чадалтай цахилгаан станцын төслийг "Макспауэр" ХХК хэрэгжүүлж байна.

Энэхүү 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь Монгол Улсын "Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль", холбогдох салбарын хууль тогтоомж, үндэсний стандарт (MNS), мөн Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-ийн гүйцэтгэлийн стандартын дагуу боловсруулагдсан.

Төлөвлөгөөний гол зорилго нь цахилгаан станцын барилга угсралт ба ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцад агаар, ус, хөрсний орчин, биологийн олон янз байдалд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах, орчны хяналт-шинжилгээ явуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, орон нутгийн иргэд болон байгаль орчны асуудал хариуцсан төрийн байгууллагад хэрэгжилтийг ил тод тайлагнахад оршино.

1.2 Танилцуулга

“Макспауэр” ХХК нь Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт орших “Хүрэн гол”-ын нүүрсний уурхайг түшиглэн 300 МВт хүчин чадалтай цахилгаан станц барих төслийг хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд баригдах “Хүрэнгол” ЦС нь Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт байрлах ба Алтай-Улиастайн эрчим хүчний систем /ЭХС/-д хамаарна. Алтай-Улиастайн Эрчим хүчний систем нь Тайшир-Улиастай-Тэлмэн чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ ашиглагдаж байгаа бөгөөд цаашлаад Тэлмэн-Мөрөн чиглэлийн 110 кВ-ын ЦДАШ-аар дамжуулан Төвийн бүсийн ЭХС-д холбогдож байна. Говь-Алтай, Завхан аймгуудын бусад сумд 35кВ, 15 кВ, 10 кВ-ын ЦДАШ-аар дамжуулан тус тус Алтай-Улиастайн ЭХС-ээс тэжээгдэж байна. Баруун бүсийн ирээдүйн хөгжил, шинээр бий болох аж үйлдвэрийн төслүүд, эдийн засгийн кластер, чөлөөт бүсүүд, цахилгаан дамжуулах сүлжээний тэлэлтийг тооцоход 2045 оны түвшинд 750 МВт-ын цахилгааны чадлын хэрэгцээг хангахын тулд 800 МВт цахилгааны чадал шаардлагатай болно. Баруун бүсийг Төв Азийн орнууд, Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зах зээлтэй холбогдсон, Дэлхийн өвд бүртгэлтэй Увс нуурын сав газар, Монгол Алтай, Хангайн нурууны байгалийн унаган төрх, олон угсаатны түүх, соёлын өв, мөн эрчим хүчний нөөцөд тулгуурлан “Эрчим хүчний төрөлжсөн бүс” болон байгалийн аялал жуулчлалын дэд бүс болгон хөгжүүлэхээр бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгасан байна. Дээрх хөгжлийн бодлого болон эрчим хүчний бодит хэрэгцээнд үндэслэн, Хүрэн голын нүүрсний ордын нөөцөд түшиглэсэн 300 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станцын төслийг хэрэгжүүлснээр Баруун бүсийн үйлдвэржилт, дэд бүтцийн тэлэлтийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилготой.

Талбайн солбилцлын цэг

№	Уртараг	Өргөрөг
1	95° 14' 10.39"	45° 47' 51.88"

2	95° 14' 10.36"	45° 48' 1.32"
3	95° 14' 26.24"	45° 48' 1.32"
4	95° 14' 26.15"	45° 47' 51.81"

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Говь-Алтай аймгийн Төгрөг сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт оршдог. Хүрэн гол төслийн талбай нь Улаанбаатар хотоос Баруун урагш ойролцоогоор 1130 км, Алтай хотоос баруун урагш ойролцоогоор 130 км, төгрөг сумын төвөөс зүүн тийш 30 км зайд байрлана.

2.1. Байгаль орчны физик ба биологийн суурь төлөв байдал

Уур амьсгал ба агаарын чанар:

Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Жилийн дундаж салхины хурд 3.6 м/с, хаврын улиралд 4.0–4.7 м/с хүрч салхилаг. Нийт хур тунадасны 93% нь 4–9 дүгээр сард ордог. Суурь агаарын чанар нь үйлдвэрлэлийн бохирдолгүй цэвэр бөгөөд агаарын тоосжилт нь байгалийн шороон шуурганы гаралтай.

Усны нөөц ба сав газар:

Монгол орны усны сав газрын ангиллаар Хүйсийн говь-Цэцэг нуурын ай савд хамаарна. Газрын доорх усны нөхөгдөх нөөц 354 сая м³. Төслийн талбайгаас 2 км-т орших Хүрэн голын ус нь TDS=287 мг/л (EC=0.684 dS/m) бүхий дунд зэргийн эрдэсжилттэй, цэвэр ус юм. Технологийн цэвэр усны хэрэгцээ жилд 89,702.4 м³ (2.85 л/с) бөгөөд батлагдсан 9 л/с нөөц нь хэрэгцээг бүрэн хангана.

Хөрсөн бүрхэвч ба топографи:

Хээржүү цөлийн цайвар бор хөрс давамгайлсан. Өнгөн үе нь механик бүрэлдэхүүнээр сул, чулуулаг ихтэй, органикийн агуулга бага (0.3–0.8%), салхины ба усны эрозид маш өртөмтгий эмзэг тогтоцтой.

Биологийн олон янз байдал:

Ургамалжилтын тусгаг бүрхэц 0–20% (таана, хөмүүл, агь, хялгана). Бүс нутагт хөхтөн 19, шувуу 52, мөлхөгч 5 зүйл бүртгэгдсэн. Төслийн талбай нь өөрчлөгдсөн амьдрах орчинд хамаарах тул онцгой эмзэг экосистемд шууд давхцаагүй.

Тусгай хамгаалалттай газар нутаг:

Төслийн талбайгаас хойд зүгт 4 км зайд Шаргын байгалийн нөөц газар, 15 км зайд Хар Азарганы нурууны байгалийн нөөц газар байрладаг.

2.2. Нийгэм, эдийн засаг ба газар ашиглалтын төлөв байдал

Хүн ам ба засаг захиргаа:

Төгрөг сум нь 2025 оны байдлаар 1,942 хүн амтай, 565 өрхтэй. Төсөл хэрэгжих 1-р баг (Хүрэн гол)-т хүн амын 24% нь оршин суудаг. Сумын төв нь Алтай хотоос 145 км, Улаанбаатараас 1,145 км зайд оршино.

Эдийн засаг ба амьжиргаа:

Мал аж ахуй (96.5 мянган толгой мал, тэмээний тоогоор аймагтаа тэргүүлдэг) болон уул уурхай (Хүрэн голын нүүрсний орд 185.9 сая тн нөөцтэй) нь сумын эдийн засгийн хоёр гол тулгуур багана юм.

Эрүүл ахуйн хамгаалалтын бүс:

Төслийн 10 га талбайн 1000 метрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн захад өвөлжөө, хаваржааны 2 айл байгаа.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Агаарын чанар:

Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тоосжилтын эх үүсвэрүүдийг услах, машины хурдыг хязгаарлах, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх, шатах тослох материал бодисын асгарч алдагдахаас сэргийлэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. Монгол Улсад мөрдөгдөж буй утаа болон бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу хяналт хийж түүнд нийцүүлэх, тээврийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй түлш, шатахууны чанарт хяналт тавих, тээврийн хэрэгслийг засаж, сайжруулж хөдөлгүүрээс гарч байгаа утааны хэмжээг стандарт (MNS4804:992)-ын шаардлага хангах хэмжээнд байлгах зэрэг болно.

Хавар, намрын улиралд салхины хурд ихсэж, шороон шуурганы давтамж нэмэгдэх, салхины нөлөөгөөр ууршилт нэмэгдэж, хуурайшилт эрчимжихийг цаашдын үйл ажиллагааны төлөвлөлтөнд харгалзан үзэх шаардлагатай.

Ажлын байрны дотоод орчинд Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2014.11.11-ний өдрийн дүгнэлтийн дагуу агааржуулах системийг сайжруулж ажиллах. Хөдөлмөрлөх орчны сөрөг хүчин зүйлийн нөлөөлөл их, бага, хэмжээгээр өртөх нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, осол, өвчлөл, хордлого үүсгэдэг тул ажил олгогч Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1-д заасан "үйлдвэрлэлийн явцад бий болсон хими, физик, биологийн хүчин зүйл нь ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, техник, зохион байгуулалтын арга хэмжээ авах" гэсэн заалтыг үндэслэн уг арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төлөвлөгөө, хамтын гэрээнд тусган зарцуулах нь зүйтэй.

3.2. Гадаргын болон гүний ус:

Шатах тослох материал алдагдах үед авах урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гүний ус ашиглалтыг хянах, багасгах, мөн ундны ус хадгалах, нөөцлөх, хэмнэлттэй зарцуулах, усны бохирдлыг бууруулах боломжийг бүрдүүлж эдгээр үйл ажиллагаанд тохируулсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, ахуйн хэрэгцээнд ашиглахаар хурын ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай байх, Хүрээлэн буй орчинд гаргаж буй хаягдал бохир ус нь MNS 4943:2014, "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, Ерөнхий шаардлага" стандартын шаардлагыг хангасан байх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

3.3. Хөрсөн бүрхэвч:

Төслийн үед хөрсний эвдрэлийг хамгийн бага байлгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг алдалгүй хийх, хатуу шингэн хог хаягдлыг тухай бүрт нь цэвэрлэх, зөвшөөрөгдсөн газарт хаях, шатах тослох материал асгарах зэргээс хөрс бохирдохоос

сэргийлэх арга хэмжээг бүрэн авч хэрэгжүүлж байх, төслийн төлөвлөсөн талбайгаас гадна машин техник байрлуулахгүй байх, олон салаа зам гаргуулахгүй байх тал дээр анхаарах хэрэгтэй.

3.4. Ургамлан нөмрөг:

Төсөл хэрэгжих талбай орчмын ургамал нөмрөг маш эмзэг. Машин техникийн болон хүний нөлөөгөөр ургамалан нөмрөг үндсэн төрхөө алдаж, бүрдэл нь цөөрч, бүрхэц нь сийрэгжсэнээс хөрс гэмтэх, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг шарилжны төрлийн хог ургамал давамгайлах магадлал ихтэй.

Эвдэгдсэн газрыг зохих стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх, машин, өөрөө явагч хэрэгслийн хөдөлгөөн, нөлөөллийг тухайн тогтоогдсон зурваст байлгах арга хэмжээ авах, өнгөн хөрсийг тусгайлан хуулан авч тухайн газрын ойролцоо овоолго үүсгэн хадгалж, сүүлд нь тухайн газрыг нөхөн сэргээхэд ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаануудыг цаг алдалгүй хийх хэрэгтэй.

Төслийн талбайд олон наст ургамлаар зүлэгжүүлэлт хийх, эвдэгдсэн газрыг зохих стандартын дагуу хэлбэржүүлж, нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэхдээ нутгийн унаган ургамлыг сонгох, машин, өөрөө явагч хэрэгслийн зогсоолтой болох, шатах тослох материал ашиглаж байгаа үед шүүрүүлэхгүй байх арга хэмжээ авч байх шаардлагатай.

3.5. Амьтны аймаг:

Төсөл хэрэгжих үед амьтны аймгийг ажиглаж хяналт явуулах нь тухайн бүс нутгийн амьтны аймгийн талаар шинжлэх ухааны мэдээ баримтыг цуглуулах боломж олгоно. Төслийн талбайн ойролцоо амьдрах амьтад дуу чимээ, тоосны бохирдол болон үүрэнд шууд нөлөө үзүүлснээр амьтад амьдрах орчноо алдах үргэж дайжиж болзошгүй. Төслийн барилгын ажлаас үүсэх нүх, тээврийн хөдөлгөөн ихэссэнээр осол гарч болзошгүй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

4.1. Агаарын чанарыг хамгаалах ба тоосжилтыг бууруулах

• Барилга угсралт, газар шорооны ажил болон авто тээврийн замын тоосжилтыг дарах зорилгоор усжуулалтыг дулааны улиралд тогтмол хийх;

• Цахилгаан станцын яндангийн бохирдуулах бодисын ялгарлыг тасралтгүй хянах CEMS системийг ТЭЗҮ-ийн дагуу суурилуулах бэлтгэлийг хангах;

• Үнс, тоос баригч төхөөрөмж болон цахилгаан шүүлтүүрийн ажиллагаанд хяналт тавих, авто тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт хамруулах (жилд 1 удаа).

4.2. Газрын доорх усны нөөцийг хамгаалах ба бохирдлоос сэргийлэх

• Химийн бодисын агуулах болон түлшний савны орчимд нэвчилтгүй бетон суурь, хоёрдогч хамгаалалтын далан ашиглах;

• Эрсдэлтэй цэгүүдэд газар доорх усны мониторингийн 2 цооног шинээр байгуулж, Усны газрын нэгдсэн системтэй холбох;

• Төслийн технологийн усны хэрэглээнд битүү хөргөлтийн систем нэвтрүүлж, усыг эргүүлэн ашиглах дараалалд хяналт тавих.

4.3. Хөрсний бүрхэвч ба газрын хэвлийг хамгаалах, нөхөн сэргийлэх

• Барилга угсралтын ажил эхлэхийн өмнө төслийн талбайн 15.0 мянган м³ үржил шимт шимт хөрсийг хуулан авч, зориулалтын талбайд ангилан хадгалах (MNS 5916:2008);

• Машин механизмын түлш тосны асгаралтаас сэргийлэх иж бүрдлийг (Spill kit) байршуулах;

• Хог хаягдлын түр цэг байгуулж, ахуйн ба аюултай хог хаягдлыг ангилан ялгах битүүмж бүхий саваар хангах.

4.4. Биологийн олон янз байдал ба “тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

• Шувууд цахилгаан дамжуулах шугамд мөргөдхөөс сэргийлэх үргээгч болон харагдах байдлыг нэмэгдүүлэх 10 тэмдэглэгээ суурилуулах;

• Зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөн, байршилд 24 цагийн мониторинг хийх 4 камер суурилуулах;

• Монгол Улсын Ерөнхийлөгчийн 58-р зарлигийн дагуу Төгрөг сумын төвд 1.0 га талбайд 500 ширхэг мод тарьж “Сумын төвийн төгөл” байгуулах (харгана, жигд, улаан сухай, хайлаас).

4.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, осол эрсдэлийн удирдлага ба ил тод байдал

• Хор аюулын лавлах (MSDS) ашиглах, ажилтнуудад ХАБЭА, химийн бодистой харьцах сургалт явуулах, иж бүрэн ХХХ-ээр хангах;

• Онцгой байдлын (гал, дэлбэрэлт) урьдчилсан сургуулилалтыг ОБЕГ-тай хамтран зохион байгуулах;

• 2026 оны БОМТ-ний хэрэгжилтийн жилийн тайланг 2026 оны 11 сарын 01-ний дотор БОУАӨЯ ба Аймгийн БОГ-т хүргүүлэн дүгнүүлж, орон нутгийн иргэдэд мэдээлэх.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны бүрдэл хэсгүүдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах зорилгоор 2026 онд нийт 48,200,000.0 төгрөгийн төсөв бүхий дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлнэ:

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (₮)	Тоо хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын бохирдол	Яндангийн ялгарлыг тасралтгүй хянах дотоод хяналтын мэдээ тайлбан боловсруулах	Агаарын орчин	Жилд 12 удаа	Сар бүрийн тайланд оруулж дотоод төсвөөр шийдвэрлэнэ			2026 онд барилгын ажил явагдаж байгаа тул яндангийн ялгарал тайлан гаргах боломжгүй	Агаарын тухай хууль 17 дугаар зүйл 17.1
2		Томоохон суурин эх үүсвэрээр бүртгүүлэх, төлбөр тооцоог жил бүр хийх	Агаарын орчин	Удаа	1,000,000	1	1,000,000	2026 онд барилгын ажил явагдаж байгаа тул эх үүсвэрээр бүртгүүлэх боломжгүй дараа жилийн төлөвлөгөөнд тусгана	Агаарын тухай хууль 18 дугаар зүйл 18.1

3		Үнс тоос баригч төхөөрөмжийн шүүлтүүрийн хэвийн ажиллагааг тогмтол хянаж, ашиглалтын нөхцөл болон ажлын ачааллаас хамааран шүүлтүүрийг солих Хүйтний улиралд сард 1 удаа, дулааны улиралд 3 сард 1 удаа сольж шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт хугацаанаас өмнө шинэчлэх	Агаарын орчин	Хүйтний улиралд сар бүр	500,000	4	2,000,000	2026 оны төсөвт тусгагдсан боловч Барилгын ажил дуусаагүй тул дараа жилийн төлөвлөгөөнд тусгагдана	Агаарын тухай хууль
				Дулааны улиралд 3 сард 1 удаа	500,000	2	1,000,000		
4	Авто тээврээс ялгарах хий	Тээврийн хэрэгслийг жил бүр техникийн үзлэгт хамруулах	Агаар орчин	Сар бүр	100,000	10	1,000,000	2026 он 11 сар	Автотээврийн тухай хууль
5	Газрын доорх усны бохирдол	Химийн бодис агуулах орчимд нэвчилтгүй бетон суурь, далан ашиглах	Газар доорх ус	Тогтмол	Дотоод төсөв			2026 он станц Барилгын ажил явагдаж байгаа тул дараа жилийн төлөвлөгөөнд тусгана	Усны тухай хууль
6	Газрын доорх усны бохирдол	Эрсдэлтэй цэгүүдэд газар доорх усны хяналтын цооног байгуулах, усны газрын нэгдсэн мониторинг системтэй холбуулах	Газар доорх ус	Жилд	500,000	2	1,000,000	2026 он 11 сар	Усны тухай хууль, MNS:5663:2009 Монгол улсын “Усны чанарын ерөнхий шаардлага, шалгах арга”

7	Газрын доорх ус бохирдох	Усны эх үүсвэрт гүний худгийн хяналтын хөтөлбөр хэрэгжүүлэх	Газар доорх ус	Тогт мол	300,000	2	600,000	2026 он 11 сар	Усны тухай хууль, MNS:5663:2009 Монгол улсын “Усны чанарын ерөнхий шаардлага, шалгах арга”
8	Хөрс бохирдол	Машин механизмын түлш, тосны санамсаргүй асгаралтаас хөрсний химийн бохирдол үүсэх боломжтой тул асгаралтын иж бүрдэл байршуулах	Хөрс	Туха й бүр	1,200,000	1	1,200,00 0	2026 он 12 сар	Хөрс хамгаалах тухай хууль
9	Хөрсний бохирдол	Хог хаягдлын түр цэгийг байгуулж, битүүмж бүхий ангилсан зориулалтын саванд хаях	Хөрс	Жилд	Дотоод төсөв			2026 он 11 сар	MNS 5850:2019 Хог хаягдалын тухай хууль
10	Хөрсний үржил шимт үе давхарга алдагдах, хөрс эвдрэх бохирдох	Барилга угсралт болон газар шорооны ажил эхлэхийн өмнө төслийн талбайн шимт хөрсний үе давхаргын зуаан, тархалтыг тодорхойлж, үржил шимт хөрсийг тусад нь хуулан ангилж хадгалах	Хөрс	м3	15.000 м3 орчим		1,500,00 0	2026 он 6, 7,8 сар	MNS 5916:2008 “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт”
11	Шувууд гэрэлтүүлэгт татагдах	Доош чиглэсэн, бага таталттай гэрэлтүүлэх ашиглах	Амьтдын амьдрах орчин	Шир хэг	1,071,400	14	15,000,00 0	2026 он 9 сар	Амьтны тухай хууль

12	Шувуудын шилжилт хөдөлгөөн	Төслийн талбайн цахилгаан дамжуулах шугамд шувууд мөргөлдөж, цохиулж үрэгдэх эрсдэлийг бууруулах зорилгоор шувуу үргээгч болон харагдах байдлыг нэмэгдүүлэх тэмдэглэгээ суурилуулах	Амьтдын амьдрах орчин	Тогт мол	150,000	10	1,500,000	2026 он 11 сар	Амьтны тухай хууль
13	Амьтдын шилжилт хөдөлгөөн	24 цагийн зэрлэг амьтдын мониторинг хийх камер суулгах	Амьтдын амьдрах орчин	Улир алд	2,000,000	4	8,000,000	2026 он 11 сар	Амьтдын тухай хууль
14	Хууль бус агнуур	Амьтан хамгаалах, тэдгээрийн ач холбогдлын тухай сургалт зохион байгуулах	Амьтдын амьдрах орчин	Жилд 1 удаа	800,000	1	800,000	2026	Амьтны тухай хууль
	ДҮН						**30,600,000 ₮**		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННҮ тайлангийн дагуу мод тарих үйл ажиллагааг 2026 оны БОМТ-ний төсвөөс ангид, үндсэн хөрөнгө оруулалтын хүрээнд шийдвэрлэхээр тусгагдсан болно

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлт, тохижилтын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Мод тарих	Хайлаас мод	ширхэг	200	20,000	4,000,00	2026	Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол
			Жигд	Ширхэг	200	24,000	4,800,000		
			Улаансухай	Ширхэг	200	32,000	6,400,000		
			Харгана	Ширхэг	200	12,000	2,400,000		
			Бүйлс	ширхэг	200	18,000	3,600,000		
	НИЙТ ДҮН						**21,200,000 ₮ ***		

** Санамж: Мод тарилтын 21.2 сая ₮-ийн санхүүжилт нь төслийн үндсэн хөрөнгө оруулалтын төсвөөс гарна.*

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн болон палеонтологийн болзошгүй дурсгалууд	Нэмэлт археологийн хайгуул, авран хамгаалах судалгаа хийлгэ	Төслийн нөлөөллийн бүс	1 судалгаа	11,223,240	11,223,240	2013 онд хийгдэж байсан судалгаан зардал,	Түүх, соёлын өвийг хамгаалах тухай хууль

							нэмэлтээр зардал гарсан тохиолдолд хөрөнгө гаргаж оруулна	
	НИЙТ ДҮН					**11,223,0240 ₮**		

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Ажилчдын бие өвдөх, халдварт өвчин	Ажилчдын эрүүл мэндийн урьдчилан болон давтан үзлэг, вакцинжуулалт, эмнэлгийн анхан шатны тусламж	Нийт ажилтан	188	Дотоод төсөв	Дотоод төсөв	2026	ХАБЭА-ын тухай хууль (2022), ISO 45001
2	Гал түймэр урьдчилан сэргийлэх	Автомат гал унтраах систем, галын дохиолол, галын сургалт, дадлага сургууль	Нийт ажилтан	188	Дотоод төсөв	Дотоод төсөв	2026	Галын аюулгүй байдлын тухай хууль (2015), ISO 45001

3	Үйлдвэрлэлийн осол, гэмтэл	XXX (PPE)-ээр хангах, ХАБЭА сургалт, ослын бүртгэл, дотоод аудит	Нийт ажилтан	188	-	Дотоод төсөв	2026	ISO 45001, MNS 12.4.013
4	Химийн бодис, түлшний харьцах эрсдэл	Хор аюулын лавлах хэрэглэх, хадгалалтын журам, асгаралтын иж бүрдэл байршуулах	Эрсдэлтэй ажлын байр	2	1,200,000	1,200,000	2026 он 11 сар	Химийн хорт бодисын тухай хууль, ISO 14001
5	Онцгой байдал (гал, дэлбэрэлт)	Онцгой байдлын төлөвлөгөө батлах, ОБЕГ-тэй хамтарсан сургалт	Үйлдвэрийн бүс	1	1,000,000.0	1,000,000	2026 он 11 сар	Онцгой байдлын тухай хууль, ISO 45001
6	Дуу чимээ, доргионы нөлөө	Дуу чимээний хэмжилт багаж, чихний хамгаалалт, ажлын байрны эргэлт	Эрсдэлтэй ажлын байр	8	100,000.0	800,000	2026 он 11 сар	MNS 5002, ISO 45001
7	Ажлын стресс, сэтгэлзүйн ачаалал	Ээлжийн зохицуулалт, амралтын горим, зөвлөгөө	Нийт ажилтан	188	-	Дотоод төсөв	2026	Хөдөлмөрийн тухай хууль, ISO 45001
8	Зам тээврийн осол	Жолоочийн сургалт, тээврийн хэрэгслийн үзлэг, хурдны дэглэм	Тээврийн нэгж	40	-	Дотоод төсөв	2026	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
	НИЙТ ДҮН					**3,000,000 ₮**		

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах,	Сөрөг нөлөөллийн	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (₮)	Тоо хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх	Баримтлах эрх зүйн баримт бичиг

		бууруулах арга хэмжээ	хамрах хүрээ					хугацаа	
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хатуу хог	Ангилан ялгах (органик/органик бус), зориулалтын сав, ТҮК/гэрээт тээвэрлэлт, бүртгэл	ЦС талбай	сар	550.0	12	6,600,000	2026	Хог хаягдлын тухай хууль (2017)
2	Үйлдвэрийн хатуу (аюултай бус) (металл, картон, паллет, стрейч, кабель)	Түр хадгалалтын талбай (битүү шал, тэмдэглэгээ), дахин ашиглалт/дахин боловсруулалт, гэрээт байгууллагад шилжүүлэх	ЦС талбай	жил	Дотоод төсөв	1	Дотоод төсөв	2026 онд хийгдэхээр төлөвлөсөн ч барилгын ажил дуусаагүй тул дараа жил рүү оруулахаар болсон	Хог хаягдлын тухай хууль (2017)
3	Шаталтын хатуу үлдэгдэл (саж/тоос/үнс – бага хэмжээтэй)	Угаа цэвэрлэгээний төхөөрөмжийн баригдсан тоос/сажийг битүү саванд цуглуулах, чийгшүүлж тоосролгүй тээвэрлэх, зөвшөөрөлтэй хүлээн авагчид шилжүүлэх	ЦС талбай	жил	Дотоод төсөв	1	Дотоод төсөв	2026 онд хийгдэхээр төлөвлөсөн ч барилгын ажил дуусаагүй тул дараа жил рүү	Агаарын тухай хууль; (түлшний үнслэг 0.05–0.14%)

								оруулахаар болсон	
4	Химийн бодисын сав баглаа боодол (FeCl3/PAC, HCl, NaClO2, метабисульфит, NaOCl, идэмхий бодис, өнгөр арилгагч гэх мэт)	Химийн бодисын савыг 'бохирдсон савлагаа' гэж ангилж тусад нь цуглуулах, шошголох, агуулахад битүү хадгалах, Тусгай зөвшөөрөлтэй байгууллагад шилжүүлэх	Ус цэвэрлэгээ / хими хэсэг	жил	Дотоод төсөв	1	Дотоод төсөв	2026 онд хийгдэхээр төлөвлөсөн ч барилгын ажил дуусаагүй тул дараа жил рүү оруулахаар болсон	Хог хаягдлын тухай хууль; ТЭЗҮ-д тусгасан химийн бодисууд
5	Аюултай хог (ашигласан тос, тосны шүүлтүүр, тос шингээсэн алчуур, сорбент, аккумулятор)	Аюултай хогийн агуулах (битүү шал, 2догч хамгаалалт), MSDS/шошго, бүртгэл, Тусгай зөвшөөрөлтэй тээвэрлэгч/устгагчид шилжүүлэх	ЦС талбай	Сар бүр	Дотоод төсөв	1	Дотоод төсөв	2026 он 10 сар	Хог хаягдлын тухай хууль; ХАБЭА
6	Шингэн хаягдал (ахуйн бохир ус, тослог ус)	Тос-ус тусгаарлагч + цэвэрлэгээ/саармагжуулалт, стандарт хангуулж зайлуулах; лаг үүсвэл тусад нь ангилж тээвэрлэх	ЦС талбай	Сар бүр	Дотоод төсөв	1	Дотоод төсөв	2026 он 11 сар	Усны тухай хууль; MNS 4943:2000
	НИЙТ ДҮН						**6,600,000 ₮**		

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Тайлбар	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Агаар дахь нийт тоосонцор	Үйлдвэрийн дотоод зам, түлш хадгалах хэсэг, үйлдвэрийн хашааны гадна орчин	Жилд 4 удаа (улирал бүр)	Дотоод төсөв			2026 он 12 сар зөвшөөрөлтэй компаниар хэмжилт хийлгэнэ	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн Ерөнхий Шаардлага MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS4990:2023 Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2	Агаар дахь арван микрометрээс бага ширхэгтэй тоосонцор	Үйлдвэрийн хашааны салхины дээд болон доод чиглэл	Жилд 4 удаа	Дотоод төсөв			2026 он 12 сар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
3	Агаар дахь хоёр хагас микрометрээс бага ширхэгтэй тоосонцор	Үйлдвэрийн хашааны салхины дээд болон доод чиглэл	Жилд 4 удаа	Дотоод төсөв			2026 он 12 сар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
4	Агаар дахь хүхрийн давхар исэл	Үйлдвэрийн хашааны зааг, салхины доод чиглэл	Жилд 4 удаа	Дотоод төсөв			2026 он 12 сар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ

5	Агаар дахь азотын давхар исэл	Үйлдвэрийн хашааны зааг	Жилд 4 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
6	Агаар дахь нүүрстөрөгчийн дутуу исэл	Үйлдвэрийн хашааны зааг	Жилд 4 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
7	Яндангийн ялгарлын найрлага (хүхрийн давхар исэл, азотын исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, тоосонцор)	Цахилгаан станцын яндан	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он төлөвлөгдсөн ч барилгын ажил дуусаагүй тул дараа жилийн төлөвлөгөөнд тусгана	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ
8	Усны чанар (үстөрөгчийн ион, нийт хатуулаг, кальци, магни, натри, кали, сульфат, хлорид, нитрит, нитрат, аммони, тослог бодис)	ДЦС-д ашиглагдах ус	Жилд 4 удаа	Жилд 2,000.0 мянган төгрөг	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 4943:2000 Бохир ус. Ерөнхий шаардлага; Монгол Улсын стандарт MNS 5663:2009 Усны чанар
9	Тослог ус	Түлш хадгалах талбайн тос-ус тусгаарлагчийн гаралт	Жилд 2 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 4586:1998 Усны орчны чанар
10	Гадаргын ус (хэрэв байвал)	Төслийн талбай орчмын гадаргын ус	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 5663:2009 Усны чанар

11	Хөрсний бохирдол (үстөрөгчийн ион, давсжилт, нефтийн бүтээгдэхүүн, хар тугалга, кадми, хром, зэс, никель, цайр)	Түлш хадгалах талбай, тос солих хэсэг	Жилд 2 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 5850:2008 Хөрсний чанар
12	Хөрсний механик эвдрэл	Үйлдвэрийн дотоод зам, талбай	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 3297:1991 Хөрс хамгаалалт
13	Асгаралтаас үүдэх хөрсний бохирдол	Асгаралт гарсан хэсэг	Шаардлагатай үед	Дотоод төсөв	Тухай бүр асгасан газрыг өөрсдийн төсвөөр цэвэрлэж арчилна	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
14	Орчны дуу чимээний түвшин	Үйлдвэрийн хашааны зааг	Жилд 1 удаа	Жилд 1,500.0 мянган төгрөг	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 5002:2000 Дуу чимээ
15	Ургамлын зүйлийн бүрдэл, зүйлийн тоо	Үйлдвэрийн талбай болон түүний ойролцоох нөлөөллийн бүс	Жилд 1 удаа (ургамал ургалтын үед)	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 3773:1998 Байгалийн ургамал. Судалгааны арга; Олон улсын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ургамлын мониторингийн сайн туршлага
16	Ургамлын бүрхэц, талбайн өөрчлөлт	Үйлдвэрийн хашаа, зам талбай, дэд бүтэц орчмын бүс	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 5918:2008 Газрын нөхөн сэргээлт. Ерөнхий шаардлага

17	Ховор, эмзэг ургамлын тархалт (хэрэв илэрвэл)	Үйлдвэрийн талбай болон хамгаалалтын бүс	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Байгаль орчныг хамгаалах тухай хууль; Ургамлын аймгийн тухай хууль
18	Нөхөн сэргээлт, мод бутны тарилтын амьдралт	“Тэрбум мод” аян хүрээнд тарьсан талбай	Жилд 2 удаа (хавар, намар)	Дотоод төсөв	2026 он 12 сар	Монгол Улсын стандарт MNS 5918:2008; Олон улсын нөхөн сэргээлтийн сайн туршлага
19	Шувуудын зүйлийн бүрдэл, тоо толгой	Үйлдвэрийн талбай, яндан орчим, хамгаалалтын бүс	Жилд 2 удаа (үржлийн болон нүүдлийн үе)	Жилд 2,000.0 мянган төгрөг	2026 он 12 сар	Амьтны аймгийн тухай хууль; Олон улсын биологийн мониторингийн сайн туршлага
20	Шувуудын осол, мөргөлдөөн (яндан, шугам, барилга)	Үйлдвэрийн талбай	Улирал тутам	Дотоод төсөв	2026 он 12 сар	Олон улсын байгаль орчны менеджментийн төлөвлөгөө
21	Жижиг хөхтөн амьтдын ажиглалт	Үйлдвэрийн талбайн орчмын бүс	Жилд 1 удаа	Дотоод төсөв	2026 он 12 сар	Амьтны аймгийн тухай хууль
22	Нүүрсний цацраг хянах шинжилгээ	Ажлын байр, гамма үүсгүүр ашиглах талбай, хүрээн нүүрснээс	Барилгын ажлын хугацаанд, ашиглалтын хугацаанд	Дотоод төсөв	2026 он төлөвлөсөн ч барилгын ажил дуусаагүй тул дараа жилийн төлөвлөгөөнд оруулна	MNS, IAEA safety standards, цацрагийн аюулгүй ажиллагааны журам

	НИЙТ ДҮН					**4,000,000 ₮**		

11. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв (₮)	Хэрэгжүүлэх хугацаа			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 Он				
			9	10	11		
	1	2	3	4	5	6	7
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн засварлах	Дотоод зохион байгуулалтаар	+			Байгаль орчны нэгж	Дотоод журам гарган мөрдөж ажиллана
2	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай	Дотоод зохион байгуулалтаар		+		Байгаль орчны нэгж	Сургалтыг зохион байгуулж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна

	хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах						
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, жил бүр дүгнэж Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд тайлагнах	Дотоод зохион байгуулалтаар			+	Байгаль орчны нэгж	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын дугаар а/618 тушаалын дагуу төлөвлөгөө гаргаж сум болон аймгийн байгаль орчноор хянуулж яаманд тайлагнах
	НИЙТ ТӨСӨВ	**Дотоод зохион байгуулалтаар**					

12. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРСИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал (₮)	Хариуцах албан тушаалтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7

1	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аймгийн Байгаль орчны газар	Цахим	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулах, батлуулах	11 сараас эхлэнэ	–	Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн Байгаль орчны газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
2	Төслийн талбайн ажилтнууд, орон нутгийн захиргаа	Цаасан	2026 оны жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг танилцуулж, ажлыг эхлүүлэх (ажлын жагсаалт, хугацаа, зорилт)	11 сараас эхлэнэ	–	Байгаль орчны мэргэжилтэн	Төслийн талбай
3	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аймгийн Байгаль орчны газар	Цаасан, цахим	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн явц, мониторингийн дүн	11 сараас эхлэнэ	–	Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн Байгаль орчны газар
4	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аймгийн Байгаль орчны газар	Цаасан, цахим	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлыг хүлээлгэн өгөх	11 сараас эхлэнэ	–	Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн Байгаль орчны газар
5	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Аймгийн Байгаль орчны газар	Цаасан, цахим	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн биелэлтийн тайланг танилцуулж, батлуулах	11 сарын 1-нээс өмнө	–	Байгаль орчны мэргэжилтэн	Аймгийн Байгаль орчны газар

6	Нөлөөллийн бүсийн оршин суугчид, иргэдийн төлөөлөл	Танилцуулга, хэлэлцүүлэг, тараах материал	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, мониторингийн үр дүн, гомдол хүлээн авах механизм	2026 он 11 сард	5000.0	Байгаль орчны мэргэжилтэн, олон нийттэй харилцах ажилтан	Орон нутгийн хурлын танхим
7	Нөлөөллийн бүсийн оршин суугчид, орон нутгийн удирдлага	Мэдээллийн самбар, цахим хуудас	Байгаль орчны мониторингийн үндсэн үзүүлэлтүүд, төлөвлөгөөний биелэлтийн товч мэдээлэл	Улирал тутам	5000.0	Байгаль орчны мэргэжилтэн	Төслийн талбай, цахим орчин
8	Нөлөөллийн бүсийн оршин суугчид, иргэний нийгмийн байгууллагууд	Уулзалт, санал авах	Санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэсэн байдлын танилцуулга	Шаардлагатай үед	5000.0	Байгаль орчны мэргэжилтэн	Орон нутгийн захиргаа

№	Арга хэмжээний чиглэл	Гүйцэтгэх ажил, үйл ажиллагааны агуулга	Төсөв /төгрөг/
1	**Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ**	Агаарын чанар, тооcжилт бууруулах CEMS систем, шүүлтүүр солих, авто үзлэг, усны хяналтын 2 цооног, шимт хөрс хуулан хамгаалах, шувуу үргээгч ба амьтны мониторингийн 4 камер суурилуулах	30,600,000
2	**Хог, хаягдлын менежмент**	Ахуйн ба үйлдвэрийн хог хаягдлыг ангилан ялгах, зориулалтын саваар хангах, ТҮК-иар тээвэрлүүлэх	6,600,000
3	**Орчны хяналт-шинжилгээний (мониторинг) хөтөлбөр**	Усны чанар, дуу чимээ, шувуудын мониторинг шинжилгээний зардал	4,000,000
4	**Осол, эрсдэлийн менежмент**	Химийн бодис, онцгой байдлын сургуулилалт, дуу чимээний хэмжилт	3,000,000
5	**Түүх, соёлын өвийг хамгаалах**	Нөлөөллийн бүсэд нэмэлт археологи, палеонтологийн судалгаа/Өмнөх судалгааны ажил хийгдсэн төлбөр дахин олдвор олдсон тохиолдолд хийхээр 2,000,000 төгрөг төсөвлөсөн/	11,223,240
6	**Олон нийтэд тайлагнах, иргэдийн оролцоог хангах**	Орон нутгийн иргэдэд тайлагнах хэлэлцүүлэг, мэдээллийн самбар засаж сурталчлах	2,000,000
7	Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд ногоон төгөл байгуулах	Мод тарьж суулгах /БОМТ жилийн төсөвт суугдаагүй дотоод төсвөөр хийх ажил/	21,200,000
Нийт төсөв:			**78,623,240**

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх менежментийн зардал **48 200 000** төгрөгийг төлөвлөж байгаа бөгөөд 50% болох **24 100 000** төгрөгийг Говь-Алтай аймгийн Төгрөг сумын байгаль хамгаалах сангийн дансанд Байгаль орчныг хамгаалах тухай болон бусад хуулийн зохих заалтуудын дагуу барьцаа болгон байршуулна.

2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд (БОМТ) тусгагдсан ажлууд хэрэгжиж дууссаны дараа төлөвлөгөөний биелэлтийн тайланг тухайн сумын Засаг дарга болон байгаль орчны хяналтын улсын байцаагчид танилцуулж, аймгийн Байгаль орчны газарт хянуулан, улмаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хүргүүлж баталгаажуулна.